

БНМАУ дахь их гүрнүүдийн бодлогын нөлөө, түүний үр дагавар (1932-1939)

□ Хэлмэгдүүлэлт





Хичээлийн сэдэв:

ДЭЛХИЙН II ДАЙНЫ ҮЕИЙН БНМАУ



Зөвлөлтийн ард түмэнд тусалсан нь



Дайны үеийн эдийн засаг, соёл



БНМАУ Японы эсрэг дайнд оролцсон нь



ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМЭНД ТУСАЛСАН НЬ

Монголчууд Зөвлөлтийн ард түмэнд яагаад, хэрхэн, яаж тусалсан бэ?



Гитлер ба Муссолин



1941 оны VI сарын 22-нд фашист Герман ЗХУ-д гэнэт халдан довтолж Зөвлөлт улсад эх орны дайн эхэлжээ. БНМАУ дайны эхний өдрөөс эхлэн ЗХУ-ын эвслийн талд баттай зогссон юм.



БНМАУ харилцан туслалцах гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу ЗХУ-д бүхий л чадлаараа туслахаа илэрхийлэв.



Бэлэглэлийн төв комиссыг байгуулж, манай төлөөлөгчид фронтод найман удаагийн цуваагаар 700 гаруй вагон ачаа хүргэж байв.



Мөн 32 мянган агт морь бэлэглэж, хямд үнээр хагас сая шахам морь худалдсан юм.

ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМЭНД ТУСАЛСАН НЬ



Хувьсгалт Монгол улс гэдэг танкийн цуваа, Монгол ард гэдэг нисэх онгоцны эскадрилийг байгуулж, 1942, 1943 онуудад улаан армид шилжүүлэв. Зөвхөн танкын бригадыг байгуулахад хөдөлмөрчдийн хандиваас гадна улсын сангаас 2.5 сая төгрөг, 300 кг шижир алт, 100 мянган ам. долларыг ЗХУ-д өгчээ.



"Монгол ард" нисэх эскадроны Ла-5 сенеегч онгоц. Нисэгч Александр Майоров.

1943 онд Монголын ард түмний хуримтлуулсан хөрөнгөөр Зөвлөлтийн Улаан армид нисэх онгоцны "Монгол ард" эскадриль буюу "Ла-5" загварын байлдааны 12 онгоц бэлэглэсэн.



Хувьсгалт Монгол Улс танкийн цуваа.

Эл цуваа оросоор «Хувьсгалт Монгол улс», дээд захаар нь «МАХН-ын Төв Хорооноос», «БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдээс», «БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс», «Д.Сүхбаатар», «Х.Чойбалсан», «Хатанбаатар Магсаржав», «Г.Бумцэнд», «Монголын малчдаас», «Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн гишүүдээс» гэх мэтчилэн тус цувааг байгуулахад хөрөнгө нийлүүлсэн нийгмийн бүх давхраа, албан ба олон нийтийн байгууллага, 18 аймгийн нэр бичээстэй Т-34 болон Т-70 маркийн 53 шинэ танкаас бүрэлдсэн байна.

ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМЭНД ТУСАЛСАН НЬ

Баримт 1.

Улаанбаатар хотын 4 дүгээр хорооны иргэн өндөр настан Догсомын Цэрэндулам I бэлэглэлд 110 төгрөг, 4 цэн, 3 фунгийн алтан бөгж 1ш, II бэлэглэлд 160 төгрөг, ямаан дах 1ш, элдсэн нэхий 1ш, III бэлэглэлд 2 цэн 5 фунгийн алтан бөгж 1ш, 3 цэнгийн алтан ээмэг хосоор, мөнгөн бугуйвч 1ш, IV бэлэглэлд 400 төгрөг, мөнгөн аяга 1ш зэргийг бэлэглэж байжээ.

(Нийслэлийн МАН-ын түүхэн тойм, 2015., 118)


Баримт 2.



Энгэлийн Бадам
/1908-1985/

Увс аймгийн Өмнөговь сумын харьяат. 1941-1944 онуудад Улаан армид нийт 1600 хонь, 16 атан тэмээ, 93 агт морь, 10000₮ хандивлаж **ФРОНТ БАДАМ** хэмээн алдаршиж байжээ.

ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМЭНД ТУСАЛСАН НЬ



Энэ үеийн уриа :
“БҮХНИЙГ
ФРОНТОД”
“БҮГДИЙГ ЯЛАЛТЫН
ТӨЛӨӨ”




Дайны үеийн эдийн засаг, соёл



1941 оны 11-н сард хуралдсан НТХ-ны бүгд хурал тус улсын улс төр, эдийн засаг, соёлын бүх ажлыг дайны үеийн байдалд захируулан зохион байгуулах шийдвэр гаргажээ.



Дайны үеийн хүндрэлийг давах гол нөөц нь мал аж ахуй байв.





Дайны үеийн эдийн засаг, соёл



Дайны жилүүдэд ЗХУ-ын тусламжаар ноос угаах фабрик, суран эдлэлийн фабрик, Зүүнбулагийн нүүрсний уурхай, мах комбинатын зарим фабрик завод, Чоно голын уурхайн ажил эхэлжээ.



ЗХУ-ын хүч хөрөнгөөр Сүхбаатараас Наушки хүртэл төмөр зам, Цагаан нуураас Зөвлөлтийн хил хүртэлх засмал зам, Баянтүмэн – Тамсагбулагийн нарийн төмөр зам тавигдсан байна.



Дайны фронтын хэрэгцээг хангах бололцоог өргөжүүлэхийн тулд ЗХУ-с Монголд нийлүүлэх барааг багасгаж, экспортын хэмжээг нэмэгдүүлэхийг хичээж байв.



1941 оноос Шинжлэх ухаан сэтгүүл хэвлэгдэх болов. 1943 онд зохиолчдын эвлэл байгуулагдаж, 1944 оноос “Цог” сэтгүүлийг эрхлэн гаргажээ. 1942 оноос “Улсын гавьяат багш”, “Ардын жүжигчин” цолуудыг бий болгов.



БНМАУ Японы эсрэг дайнд оролцсон нь

Монголчууд Японы эсрэг дайнд яагаад оролцох болов.



Баримт 1.

1945 оны 8 дугаар сарын 10-нд маршал Чойбалсан Монголын ард түмэнд хандан радиогоор БНМАУ нь Японд ариун дайн зарласнаа мэдэгдэж хэлсэн үгэндээ:

“Монгол Улсын иргэд ээ, Барга, Цахар, Харчин, Өвөр Монголын иргэд ээ, өнөөдөр манай арми хил давж, Өвөр Монголын нутагт нэвтэрч, маш хурдтай урагш давшлаа. Энэ нь бидний мах цусны тасархай болох Өвөр Монголыг чөлөөлж, эрх чөлөөг олгохын төлөөх үйл хэрэг юм” гэжээ.

Баримт 2.

Нэгдүгээрт, энэ дайн нь “Монгол овогтон нэгэн улс гэр болон нэгдэхийн тулд”, **хоёрдугаарт**, үүний тулд “Халх, Дөрвөд, Торгууд, Буриад, Барга, Өмнөд Монгол, Цахар, Ордос, Харчин, Дарьганга, Алашаа, Хөхнуурын Монгол зэрэг монгол овогтон, бас БНМАУ-ын газар нутагт оршин суугчид болон Казак, Урианхай зэрэг монгол овогтоныг империализмын дарлалаас мөнхөд ангижруулан, монголчуудын хэл, үндэсний соёлыг хүндэтгэн хөгжүүлж, үндэсний уламжлал, шашнаа хамгаалж, улс гэрийн эрх ашиг, тусгаар тогтнолоо батжуулах”-ын төлөө, **гуравдугаарт**, “ зоригт улаан цэрэгтэй хамтран “1936 оны ЗХУ, БНМАУ-ын харилцан туслах гэрээг хэрэгжүүлэхийн тулд” хэмээн тодорхойлжээ.

БНМАУ-ын Улсын бага хурал, Засгийн газрын бичигт



БНМАУ Японы эсрэг дайнд оролцсон нь



МАХЦ-ийн байлдааны ажиллагааг БНМАУ-ын маршал Х. Чойбалсан, дэслэгч генерал Жамьяангийн Лхагвасүрэн нар удирджээ. Монгол ардын арми **Жэхэ**, **Чуулалт** хаалгын чиглэрээр давшиж, шийдвэрлэх тулалдаан **Жанчхүүгийн даваанд** болсон юм.



БНМАУ Японы эсрэг дайнд оролцсон нь



Байлдааны явцад Монголын талаас 675 хүн амь үрэгдэж, 249 сая төгрөгийн эд агуурсын хохирол хүлээжээ.



Монгол –Зөвлөлтийн цэрэг Өвөр Монгол болон Хятадын нилээд нутгийг чөлөөлөн Квантуны армийг Хятадын бусад нутгуудад байлдаж байсан зэвсэгт хүчнээс нь тасалсан юм.



Монгол Улсын баатар Л.
Аюуш (1922-1945)



Монгол Улсын баатар Д.
Данзанваанчиг 1918-1981



Монгол Улсын баатар Л.
Дандар 1914-1986



Монгол Улсын баатар С.
Дампил 1922-1991

БНМАУ Японы эсрэг дайнд оролцсон нь

Японы эсрэг дайнд МАХЦ-ийн 21 мянган цэрэг дайчид оролцон их элсэн манхан, усгүй цөлийг даван туулж 950 км давшиж ялалт байгуулсан юм. Өвөрмонгол, хятадын чөлөөлөгдсөн нутгийн ард иргэд Зөвлөлт, Монголын дайчдыг халуун дотноор угтан авчээ.

1945.08.09

Дайн зарлав.

ЗХУ Ялтын бага хурлаар хүлээсэн үүргээ биелүүлж Японд

1945.08.10

Дайн зарлав.

БНМАУ империалист Японыг бут цохих шударга үйлсэд хувь нэмэр оруулах, өөрийн аюулгүй байдлаа бэхжүүлэх

1945.08.21

Жанчхүүгийн даваа

Ширүүн тулаан болж Л. Аюуш, Д. Данзанваанчиг нарын БНМАУ-ын баатрууд төрөн гаржээ.

1945.09.02

Бууж өгөв

Япон улс үг дуугүй бууж өгөх актад гарын үсэг зурснаар дэлхийн II дайн дуусав.



Бататгал 1:

Дэлхийн II дайны үед Монголчуудаас ЗОУ-д өгсөн бэлэглэлийн цувааны нэг хэсэг болох нисэх онгоцны эскадриль ямар нэртэй байсан бэ?

- A. Ахан дүүс В. Монгол ард С. Хувьсгалт Монгол D. Ялалтын төлөө E. Энх тайван



Бататгал 2:

БНМАУ-ын засгийн газар оны сард улсад дайн зарлав. Нөхнө үү.





- A. 1943, 6, Герман улсад В. 1944, 7, Итали улсад С. 1945, 8, Япон улс
D. 1946, 9, Хятад улсад E. 1947, 10, Манж Го улсад



Бататгал 3:

БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулсан “Монгол-Зөвлөлтийн харилцан туслалцах протокол”-д хэдэн онд гарын үсэг зурсан бэ?

- A. 1939 он В. 1937 он С. 1938 он D. 1936 он E. 1940 он





АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА.